

**ОРЛОГО БА ХӨРӨНГИЙН ТАТВАРЫГ ДАВХАРДУУЛЖ
НОГДУУЛАХГҮЙ БАЙХ, ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ЯВДЛААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН КОНВЕНЦ**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Итали Улсын
Засгийн газар,

Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх,
татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Конвенц
байгуулахыг эрмэлзэн,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

1 ДҮГЭЭР БҮЛЭГ

КОНВЕНЦИЙН ХАМААРАХ ХҮРЭЭ

1 дүгээр зүйл. Хамаарагдах этгээд

Энэхүү Конвенц нь Хэлэлцэн тохирогч хоёр Улс буюу эдгээрийн
аль нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдийг хамаарна.

2 дугаар зүйл. Хамаарагдах татварууд

1. Хэлэлцэн тохирогч Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн
нэгжүүдийн нэрийн өмнөөс орлогод ба хөрөнгөд ногдуулж буй татварууд
нь тэдгээрийг хэрхэн ногдуулж байгаа хэлбэрээс үл шалтгаалан энэхүү
Конвенцид хамаарна.

2. Орлогод ба хөрөнгөд ногдуулж буй татвар гэж нийт орлого буюу
нийт хөрөнгө болон орлого буюу хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэгт ногдуулж
буй бүх төрлийн татвар түүний дотор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн
борлуулалтын орлого, аж ахуйн нэгжээс олгож буй цалин хөлсний нийт
хэмжээ болон хөрөнгийн үнэлгээний өсөлтөд ногдуулах татварыг хэлнэ.

3. Конвенцид одоо мөрдөгдөж байгаа дараах татварууд
хамаарагдана:

а) Монгол Улсын хувьд:

Гаднаад харилцааны төв архив

i/ хүн амын орлогын албан татвар,

ii/ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар,

iii/ үл хөдлөх хөрөнгийн татвар

(цаашид "Монголын татвар" гэх)

б) Итали Улсын хувьд:

i/ хүн амын орлогын албан татвар,

ii/ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар,

эх үүсвэрт нь суутган авсан эсэхээс үл хамааран

(цаашид "Италийн татвар" гэх)

4. Энэхүү Конвенцид гарын үсэг зурсан өдрөөс хойш шинээр бий болсон, одоогийн татварт нэмэлт болох буюу тэдгээрийг орлох аливаа татварууд нь дээр дурдсан татваруудтай адил буюу үндсэндээ төстэй байвал энэхүү Конвенцид мөн хамаарагдана. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь өөрийн орны татварын хуульд орсон аливаа зарчмын өөрчлөлтийн талаар нөгөө талдаа мэдэгдэж байна.

2 ДУГААР БҮЛЭГ

ТОДОРХОЙЛОЛТ

3 дугаар зүйл. Ерөнхий тодорхойлолт

1. Энэхүү Конвенцид өөрөөр заагаагүй бол дор дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

а) "Монгол" гэж газар зүйн утгаар авч үзвэл Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийг хэлнэ.

б) "Итали" гэж газар зүйн утгаар авч үзвэл Бүгд Найрамдах Итали Улсын бүх нутаг дэвсгэрийг хэлнэ.

в) "Хэлэлцэн тохирогч Улс" болон "Хэлэлцэн тохирогч нөгөө Улс" гэж тухайн заалтын утгаас хамааран Монгол болон Италийг хэлнэ.

г) "этгээд" гэж хувь хүн, компани болон аливаа бусад бүлэг этгээдийг хэлнэ.

д) "компани" гэж хуулийн эрх бүхий этгээд буюу татвар ногдуулах утгаараа түүнтэй адилтгах аливаа этгээд буюу аж ахуйн нэгжийг хэлнэ.

е) "Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж" буюу "Хэлэлцэн

тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгж" гэж Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгж буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ,

ж) "олон улсын тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч Улсад голлох удирдлага нь байрладаг аж ахуйн нэгжээс хөлөг онгоц буюу нисэх онгоцоор хийх аливаа тээврийн үйл ажиллагааг хэлэх бөгөөд харин Хэлэлцэн тохирогч нөгөө Улс доторхи байрлалуудын хооронд хөлөг онгоц буюу нисэх онгоцоор хийх тээврийн үйл ажиллагаа үүнд үл хамаарна.

з) "харъяат" гэж

(i) Хэлэлцэн тохирогч Улсын иргэний харьяалалтай аливаа хувь этгээд;

(ii) Хэлэлцэн тохирогч Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу өөрийн статустай аливаа хуулийн этгээд, нөхөрлөл болон холбоог хэлнэ.

и) "эрх бүхий байгууллага" гэж,

(i) Монголын хувьд Санхүү, эдийн засгийн яам буюу түүний эрх бүхий төлөөлөгч,

(ii) Италын хувьд Эдийн засаг, санхүүгийн яам.

2. Энэхүү Конвенцийн тодорхойлогдоогүй аливаа нэр томъёог, өөрөөр заагаагүй бол, Конвенциор зохицуулагдаж буй татвартай холбогдол бүхий Хэлэлцэн тохирогч тухайн Улсын хуульд зааснаар ойлгоно.

4 дүгээр зүйл. Байнга оршин суугч

1. Энэхүү Конвенцийн зорилгоор "Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч" гэж тухайн Улсын хуулийн дагуу оршин сууж, амьдарч буй болон голлох удирдлага нь байрлаж байгаа буюу байгуулагдсан эсхүл адилтгах бусад шалтгаанаар тухайн Улсад татвар төлөх үүрэгтэй аливаа этгээдийг хэлнэ. Гэхдээ энэхүү нэр томъёо нь тухайн Улс дахь эх үүсвэрээс буюу тэнд оршдог хөрөнгөөс олсон орлогод тухайн Улсад татвар төлөх аливаа этгээдийг хамаарахгүй.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршин суугч этгээдийн статусыг дараахь байдлаар тодорхойлно.

а) байнга амьдардаг орон гэр нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно. Хэрэв уг этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түүний хувийн болон эдийн

засгийн харилцаа (язгуур эрх ашгийн төв) нь илүү ойр дөт байгаагаар нь тэндхийн байнга оршин суугч гэж тооцно.

б) хэрэв түүний язгуур эрх ашгийн төв бүхий Улсыг тодорхойлох аргагүй, эсвэл хувь этгээд Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэргүй бол хэвшмэл байдалтайгаар оршин амьдардаг Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч гэж тооцно.

в) хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсад аль алинд нь хэвшмэл байдлаар оршин амьдардаг, эсвэл алинд ч хэвшмэл байдлаар амьдардаггүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль Улсын харъяат байгаагаар нь тухайн Улсад байнга оршин суугч гэж тооцно.

г) хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсад буюу эдгээрийн аль алины харъяат, эсвэл алиных нь ч харъяат биш бол асуудлыг Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу этгээдээс бусад хувь этгээдийг Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршин суудаг бол түүний голлох удирдлага нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байрлаж байгаагаар нь тэр Улсын байнга оршин суугч гэж тооцно.

5 дугаар зүйл. Төлөөлөгчийн газар

1. Энэхүү Конвенцийн зорилгоор "Төлөөлөгчийн газар" гэж аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн явуулдаг байнгын байрлалыг хэлнэ.

2. "төлөөлөгчийн газар" гэдэгт тухайлбал;

а) аж ахуйг удирдан явуулж буй газар,

б) салбар байгууллага,

в) албан байгууллага,

г) үйлдвэр,

д) цех,

е) уурхай, ил уурхай буюу байгалийн бусад ашигт малтмал олборлож буй газар,

ё) 6 сараас дээш хугацаагаар үргэлжлэх тухайн барилгын талбай, угсралт буюу суурилуулалтын төслийн үйл ажиллагааг багтаана.

3. "Төлөөлөгчийн газар" гэдэгт дараахь үйл ажиллагаа үл хамаарна:

а) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсыг хадгалах,

үзэсгэлэнд тавих, нийлүүлэх зорилгоор аливаа байгууламжийг ашиглах,

б) зөвхөн хадгалах, үзэсгэлэнд тавих буюу нийлүүлэх зорилгоор аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсын нөөцийг байлгах,

в) өөр аж ахуйн нэгжээр зөвхөн боловсруулалт хийлгэх зорилгоор аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсын нөөцийг байлгах,

г) аж ахуйн нэгж нь зөвхөн өөртөө зориулан бараа буюу эд агуурс худалдан авах эсвэл мэдээлэл цуглуулах зорилгоор байнгын байрлал байлгах,

д) аж ахуйн нэгж нь зөвхөн өөртөө зориулан зар сурталчилгаа явуулах, мэдээллийн нөөцийг бүрдүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа хийх, бэлтгэх, туслах чанарын аливаа үйл ажиллагаа явуулах зорилгоор байнгын байрлал байлгах,

4. 5 дугаар заалтад хамаарах бие даасан эрх бүхий төлөөлөгчөөс бусад этгээд Хэлэлцэн тохирогч Улсад тухайн этгээдийн үйл ажиллагаа нь тухайн аж ахуйн нэгжид зориулж бараа, эд агуурс худалдан авахаар хязгаарлагдахгүй, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж тэрээ байгуулах эрхийг байнга эдэлдэг бол түүнийг Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газартай гэж үзнэ.

5. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад брокер, ерөнхий комиссын төлөөлөгч, бие даасан эрх бүхий бусад аливаа төлөөлөгчөөр дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газартай гэж тооцохгүй бөгөөд тэдгээр этгээд нь өөрийн тогтсон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байх нь үүний нөхцөл болно.

6. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршдог, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад үйл ажиллагаа (төлөөлөгчийн газраар дамжуулах буюу бусад аргаар) явуулдаг компанийг хянадаг эсвэл хяналтад байдаг Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани нь эдгээр компанийг харилцан төлөөлөгчийн газар гэж үзэх үндэс болохгүй.

3 ДУГААР БҮЛЭГ

ОРЛОГЫН ТАТВАР

6 дугаар зүйл. Үл хөдлөх хөрөнгөөс орох орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгөөс олсон орлогод (хөдөө аж ахуй болон ойн аж ахуйгаас олсон орлогыг оролцуулан) Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. "Үл хөдлөх хөрөнгө" гэсэн нэр томъёог тухайн хөрөнгө байрлаж

буй Хэлэлцэн тохирогч Улсын хуульд заасны дагуу тодорхойлно. Аливаа тохиолдолд, уг нэр томъёонд үл хөдлөх хөрөнгөд дагалдах өмч, хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйд ашиглагдаж буй мал, тоног төхөөрөмж, газарт суурилагдсан хөрөнгөтөй холбоотой хуулийн үндэслэл бүхий эрх, бусдын үл хөдлөх хөрөнгийг эзэмшин ашиглах эрх, ашигт малтмалын нөөц, рашаан ус болон байгалийн бусад баялгийг ашигласны төлөө буюу ашиглах эрхийн төлөө төлөх байнгын буюу байнгын бус төлбөрийн эрхийг багтаана. Харин хөлөг онгоц, нисэх онгоц үл хөдлөх хөрөнгөд орохгүй.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалт нь үл хөдлөх хөрөнгийг шууд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсвэл бусад аль ч хэлбэрээр ашиглах замаар олсон орлогод хамаарна.

4. Энэхүү зүйлийн 1 болон 3 дугаар заалт нь аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгө, болон бие даасан хувийн үйлчилгээ үзүүлэхэд ашигласан үл хөдлөх хөрөнгөөс олсон орлогод хамаарна.

7 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны ашиг

1. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Хэрэв аж ахуйн нэгж нь дээр дурдсан байдлаар үйл ажиллагаа эрхэлж байвал уг аж ахуйн нэгжийн ашгийн зөвхөн тухайн байнгын төлөөлөгчийн газарт хамаарах хэсэгт Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг өөрийн төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд уг төлөөлөгчийн газар нь төлөөлж буй аж ахуйн нэгжтэйгээ бүрэн бие даасан байдлаар харилцан адил, эсвэл төстэй үйл ажиллагааг, адил буюу төстэй нөхцөлд эрхлэн явуулж олж болох байсан ашгийг энэхүү зүйлийн 3 дугаар заалтын дагуу уг төлөөлөгчийн газрын ашиг гэж Хэлэлцэн тохирогч Улс бүрт тооцно.

3. Төлөөлөгчийн газрын ашгийг тодорхойлохдоо төлөөлөгчийн газар оршиж байгаа Хэлэлцэн тохирогч Улс болон бусад Улсад тус төлөөлөгчийн газар өөрийн зорилгоо хэрэгжүүлэхэд гаргасан зардлууд мөн түүнчлэн аж ахуйн нэгжийн хувьд удирдлагын болон ердийн захиргааны зардлыг хасч тооцно.

4. Хэлэлцэн тохирогч Улсад аливаа аж ахуйн нэгж өөрийн салбарууддаа нийт ашгийг хуваарилдаг аргаар төлөөлөгчийн газрын орлогыг тодорхойлж хэвшсэн бол Хэлэлцэн тохирогч Улс энэ хэвшсэн аргаар татвар ногдох орлогыг тодорхойлоход энэхүү зүйлийн 2 дугаар заалт ямар ч тохиолдолд саад болохгүй. Гэхдээ хэвшсэн аргаар орлогыг хуваарилсантай холбогдон гарах үр дүн нь энэхүү зүйлийн зарчмуудтай зөрчилдөхгүй байвал зохино.

5. Төлөөлөгчийн газар нь харьяалагдах аж ахуйн нэгждээ зориулан бараа буюу эд агуурс худалдан авсныг үндэслэн уг төлөөлөгчийн газрыг ашиг олсонд тооцож үл болно.

6. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад нийцүүлэн төлөөлөгчийн газарт хамаарах ашгийг тодорхойлох аргыг өөрчлөх баттай үндэслэлгүй бол жилээс жилд тогтсон нэг арга хэрэглэнэ.

7. Хэрэв ашиг нь энэхүү Конвенцийн бусад зүйлд хамааралтай орлогын төрлийг агуулсан бол тэдгээр зүйлийн заалтыг мөрдөхөд энэхүү зүйлийн заалтууд үл нөлөөлнө.

8 дугаар зүйл. Усан болон агаарын тээвэр

1. Олон улсын тээвэрт хөлөг онгоц болон нисэх онгоцны тээврийн хэрэгсэлээр тээвэр хийж олж байгаа Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн ашигт зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага нь байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

2. Хэрэв усан замын тээврийн байгууллагын голлох удирдлага нь хөлөг онгоцонд байрладаг бол энэхүү хөлөг онгоцны харьяалах боомт оршдог Хэлэлцэн тохирогч Улсад, хэрэв харьяалах боомт үгүй бол уг хөлөг онгоцны эзэмшигч байнга оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад голлох удирдлага нь байрладаг гэж үзнэ.

3. 1 дүгээр заалт нь олон улсын тээврийн байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн үйл ажиллагаанд оролцож олсон ашигт мөн хамаарна.

9 дүгээр зүйл. Хоршсон аж ахуйн нэгжүүд

1. Хэрэв:

а) Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог, эсхүл

б) тухайн этгээдүүд Хэлэлцэн тохирогч Улсын болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог бол,

Тэдгээр хоёр аж ахуйн нэгжийн хооронд тогтсон худалдаа, санхүүгийн харилцааны нөхцөл нь бие даасан аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааны нөхцлөөс ялгаатай бөгөөд тухайн аль нэг аж ахуйн нэгжид ногдох ёстой аливаа ашиг дээрх ялгаатай нөхцлийн улмаас тооцогдоогүй байвал түүнийг уг аж ахуйн нэгжийн ашигт оруулан тооцож зохих журмын дагуу татвар ногдуулж болно.

2. Хэрэв Хэлэлцэн тохирогч Улс нь тухайн улсын аж ахуйн нэгжийн ашигт Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжид ногдуулсан татварын ашгийг нэмж тооцсон бөгөөд нэмж тооцсон ашиг нь тухайн

хоёр аж ахуйн нэгжүүд хоорондоо хамааралгүй байх тохиолдолд, Хэлэлцэн тохирогч эхний Улсын аж ахуйн нэгжийн ашиг байхаар бол, Хэлэлцэн тохирогч нөгөө Улс нь тухайн ашигт ногдуулсан татварын хэмжээнд холбодох зохицуулалт хийнэ. Ийм зохицуулалтыг хийхдээ зөвхөн энэ Конвенцийн 26 дугаар зүйлд заасан хамтран зөвшилцөх журмын дагуу хийнэ.

10 зүйл. Дивиденд

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлсөн дивидендэд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ дивидендийг төлж буй компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсад тийм дивидендэд тухайн улсын хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулж болох ба гэхдээ дивиденд авагч нь түүний жинхэнэ эзэмшигч бол ногдуулах татварын хэмжээ нь дор зааснаас хэтрэхгүй:

а/ хэрэв жинхэнэ эзэмшигч нь дивиденд төлж буй компанийн хөрөнгийн 10-аас багагүй хувийг эзэмшдэг компани (нөхөрлөл бус) буюу дивидендийг тодорхойлсоноос өмнөх 12 сарын хугацаанд эзэмшиж байсан бол дивидендийн нийт дүнгийн 5 хувиас;

б/ бусад бүх тохиолдолд дивидендийн нийт дүнгийн 15 хувиас.

Энэхүү заалт нь тухайн компанийн дивиденд төлсөн орлогод ногдуулах татварт үл хамаарна.

3. Энэхүү зүйлд хэрэглэгдсэн " Дивиденд " гэсэн нэр томъёонд хувьцааны ногдол ашиг, "жоуиссанс хувьцаа", "жоуиссанс эрх", уул уурхайн хувьцаа, үүсгэн байгуулагчийн хувьцаа болон өрийн нэхэмжлэлээс бусад хэлбэрээр ашигт оролцох эрх болон бусад эрхээс үүсэх орлого мөн түүнчлэн ногдол ашгийн хуваарилалт хийж буй компанийн байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсын хуулийн дагуу хувьцааны ногдол ашгийн нэгэн адилаар татварт хамруулдаг аж ахуйн эрхээс олох орлогыг хэлнэ.

4. Хэрэв дивидендийн эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч бөгөөд дивиденд төлөгч компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газар буюу бие даасан хувийн үйлчилгээ эрхэлдэг тогтмол газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг ба дивидендийн эрх хэрэг дээрээ энэ төлөөлөгчийн газар буюу товлосон газарт шууд хамааралтай бол 1 ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын өөрийнх нь хуулийн дагуу дивидендэд татвар ногдуулна.

5. Энэхүү Конвенцийн заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнгын төлөөлөгчийн газартай бөгөөд тус байнгын төлөөлөгчийн газрын ашгаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын хуулийн дагуу нэмэлт татвар төлөх ба гэхдээ тухайн нэмэлт татвар нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад

ногдуулсан орлогын татварыг хассан ашгийн дүнгийн 5 хувиас хэтэрч болохгүй.

6. Хэрэв Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ашиг буюу орлого олж байвал нөгөө Улс уг компаниас төлж буй дивидендэд татвар ногдуулахгүй. Энэ тохиолдолд гэхдээ тухайн дивидендийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлсөн эсвэл дивиденд төлж байгаа нь хэрэг дээрээ Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газар буюу тогтмол байр байгаатай шууд хамааралтай бол татвар ногдуулж болно. Харин төлсөн дивиденд эсвэл хувиарлагдаагүй ашиг нь тухайн нөгөө Улсад бий болсон орлого эсвэл ашгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн багтааж байлаа ч тухайн компаний хувиарлагдаагүй ашигт татвар ногдуулж болохгүй.

11 дүгээр зүйл. Хүү

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ тийм хүү бий болсон Хэлэлцэн тохирогч Улсад өөрийн хуулийн дагуу уг хүүд татвар ногдуулж болох боловч хэрэв хүлээн авагч нь хүүгийн жинхэнэ эзэмшигч бол татварын хэмжээ нь хүүгийн нийт дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.

3. 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон дараах хүүг тухайн Улсад татвараас чөлөөлнө.

а. Тухайн Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу орон нутгийн эрх бүхий байгууллагууд хүүгийн төлөгч, эсхүл

б. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын Засгийн газар болон орон нутгийн эрх бүхий байгууллага, төлөөлөгч /санхүүгийн байгууллага хамаарна/-д төлсөн буюу Хэлэлцэн тохирогч Улс болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд бүхэлдээ эзэмшсэн хүү, буюу

в. Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газрын хооронд байгуулсан гэрээний дагуу хийгдсэн зээлийн хувьд аливаа бусад байгууллага буюу охин компани /санхүүгийн байгууллага хамаарна/-д төлсөн хүү,

4. Энэхүү зүйлд тусгагдсан "хүү" гэсэн нэр томъёонд барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн орлогод оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн эсэхийг үл харгалзан түүнээс орлого үүсэн бий болсон тухайн Улсын татварын хуулийн дагуу зээлдүүлсэн мөнгөнөөс орох бусад бүх орлого болон улсын сангийн орлого, зээллэг бусад үнэт цааснаас орох орлогуудыг хэлнэ.

5. Хэрэв хүү авагч эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж, тэнд нь энэ хүү бий болж байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог

товлосон газраас хувийн бие даасан үйлчилгээ эрхэлдэг бөгөөд хүү авах эрх нь дурдсан төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1, 2 болон 3 дугаар заалтыг хэрэглэхгүй. Энэ тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Улсад өөрийн хуулийн дагуу хүүд татвар ногдуулна.

6. Хүү төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улс өөрөө, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон тухайн Улсад байнга оршдог суугч, орон нутгийн эрх бүхий байгууллага бол Хэлэлцэн тохирогч Улсад хүүг бий болсон гэж тооцно. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч эсэхийг үл харгалзан хүүг төлөгч этгээд Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газартай бөгөөд үүнтэй холбогдон хүү төлөгдөж, уг хүү энэ төлөөлөгчийн газарт эсвэл товлосон газарт бий болж байгаа бол дээрх төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газар оршиж байгаа Улсад хүү бий болсон гэж үзнэ.

7. Хэрэв хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигчийн хооронд буюу тэдгээрийн болон ямар нэгэн бусад этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлж буй хүүгийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрч байвал энэ зүйлийн заалтууд эцэст дурдсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд хүүгийн төлбөрийн илүү гарсан зөрүүд Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу энэхүү Конвенцийн бусад заалтыг харгалзан татвар ногдуулж болно.

12 дугаар зүйл. Эрхийн шимтгэл

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлсөн эрхийн шимтгэлд тухайн нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсад бий болох тийм эрхийн шимтгэлд тухайн улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч гэхдээ хүлээн авагч нь эрхийн шимтгэлийн жинхэнэ эзэмшигч мөн бол тийнхүү ногдуулж буй татвар нь эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 5 хувиас хэтрэхгүй.

3. Энэхүү зүйлд хэрэглэгдсэн "эрхийн шимтгэл" гэсэн нэр томъёонд уран зохиогчийн эрх, урлаг буюу шинжлэх ухааны бүтээл, түүний дотор компьютерийн программ хангамж, уран сайхны кино буюу телевизийн нэвтрүүлэгийн бичлэг, патент, барааны тэмдэг болон дизайн, модель, зураг төсөл, нууц томъёолол буюу процессийг ашигласан буюу ашиглах эрх, үйлдвэр, худалдаа буюу шинжлэх ухааны тоног төхөөрөмж, туршлагатай холбогдсон мэдээллийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөр хамаарна.

4. Хэрэв эрхийн шимтгэлийн жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дугаар төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тэнд энэхүү орлого бий болж байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч

нөгөө Улсад оршдог товлосон газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ хийдэг түүнчлэн эрхийн шимтгэлийн төлбөр авах эрх буюу хөрөнгө нь хэрэг дээрээ энэхүү төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газарт шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг хэрэглэхгүй. Энэ тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Улсын өөрийнх нь хуулийн дагуу эрхийн шимтгэлд татвар ногдуулна.

5. Эрхийн шимтгэл төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улс өөрөө, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу тухайн Улсад байнга оршдог орон нутгийн эрх бүхий байгууллага бол уг эрхийн шимтгэлийг Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж тооцно. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суудаг эсэхийг үл харгалзан эрхийн шимтгэлийг төлж буй этгээд уг Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар эсвэл товлосон газраар дамжуулан эрхийн шимтгэлийн төлбөр төлөх үүрэг хүлээдэг бол тэрхүү төлөөлөгчийн газар эсвэл товлосон газрын оршиж байгаа Улсад эрхийн шимтгэлийг бий болсон гэж тооцно.

6. Эрхийн шимтгэлийг төлөгч болон жинхэнэ эзэмшигч буюу тэдгээрийн болон ямар нэгэн бусад этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлөгдсөн эрхийн шимтгэлийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй тохиолдолд түүнийг төлөгч ба жинхэнэ эзэмшигч хоёрын хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрвэл энэхүү зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан эцэст дурдсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүд энэхүү Конвенцийн бусад заалтыг харгалзан Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу татвар ногдуулна.

7. Хэлэлцэн тохирогч аль нэг Улсаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч болох жинхэнэ эзэмшигч техникийн үйлчилгээний хураамж авсан ба түүндээ Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар төлдөг бол эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч Улс уг хураамжийн нийт дүнгийн 5-аас хэтрэхгүй хувиар татвар ногдуулж болно.

8. Энэ зүйлд тусгагдсан "Техникийн үйлчилгээний хураамж" гэдэг нь техникийн, удирдлагын буюу зөвлөгөө өгөх аливаа үйлчилгээ үзүүлсний төлөө төлбөр хийж буй этгээдээс, ажиллагсадаас бусад аливаа этгээдэд төлж байгаа төлбөр юм. Гэхдээ Конвенцийн 14 ба 15 зүйлд дурдсан үйлчилгээнд үүнийг оруулахгүй.

13 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсны орлого

1. Зургадугаар зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлсон үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогод тийм хөрөнгө оршиж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дугаар төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглагддаг хөдлөх хөрөнгийн зарим хэсэг буюу Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харъяалагдах хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас орох орлого,

мөн түүнчлэн ийм төлөөлөгчийн газар (дангаар эсвэл бүх аж ахуйн газрын хамт) буюу ийм товлосон газрыг худалдаж борлуулснаас орох орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.

3. Олон улсын тээвэрт ашиглагдаж буй хөлөг онгоц, нисэх онгоц буюу эдгээр хөлөг онгоц, нисэх онгоцны үйл ажиллагаанд хамаарагдах хөдлөх хөрөнгө борлуулснаас олсон орлогод ийм тээврийн хэрэгслийг ашиглаж буй тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

4. 1, 2 болон 3 дугаар заалтад зааснаас бусад аливаа хөрөнгийг борлуулсаны орлогод борлуулагчийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч Улсад зөвхөн татвар ногдуулж болно.

14 дүгээр зүйл. Бие даасан хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч бие даасан шинжтэй мэргэжлийн буюу ердийн үйлчилгээ үзүүлсэнээс олсон орлогод нөхцөл байдлын улмаас тухайн Улсад татвар ногдуулж болох бөгөөд энэхүү нөгөө тийм орлогод татвар ногдуулж болно:

а) хэрэв хувь этгээд нь үйлчилгээ үзүүлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга ашиглаж болох товлосон газартай бол; тухайн тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс түүний орлогын зөвхөн товлосон газарт хамаарах хэсэгт татвар ногдуулж болно.

б) хэрэв байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад нийт байсан хугацаа нь тухайн хуанлийн жилийн эхлэл болон төгсгөх 12 сарын аль нэгний 183 өдрөөс давсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад энэ хугацаанд явуулсан үйл ажиллагаанд ногдох орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. "Мэргэжлийн үйлчилгээ" гэсэн нэр томъёонд мэргэшсэн, бие даасан шинжлэх ухаан, уран зохиол, соёл урлаг, боловсрол буюу багшлах үйл ажиллагаа, түүнчлэн эмч, мэс засалч, хуульч, инженер, архитекторч, шүдний эмч болон нягтлан бодогч нарын бие даасан үйл ажиллагааг хэлнэ.

15 дугаар зүйл. Бие даасан бус хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажил үйлчилгээ эрхлээгүйгээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн ажил хийж авсан цалин хөлс болон түүнтэй адилтгах бусад шагнал урамшилд 16, 18, 19 болон 20 дугаар зүйлд заасны дагуу зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Хэрэв ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж байгаа бол тэрхүү ажил үйлчилгээнээс олсон шагнал урамшилд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад

гүйцэтгэж буй ажил үйлчилгээний хөлсөнд олгосон шагнал урамшилд Хэлэлцэн тохирогч эхний Улсад дор дурдсан нөхцөлд татвар ногдуулна:

а) шагнал урамшил авагч нь хуанлийн жилийн эхлэл болон төгсөх 12 сарын аль нэгний нийтдээ 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байсан бол,

б) шагнал урамшлыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суудаггүй ажил олгогч өөрөө, эсвэл түүний нэрийн өмнөөс төлсөн бол, болон

в) шагнал урамшлыг ажил олгогчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дугаар төлөөлөгчийн газар буюу товлосон газар нь төлөөгүй бол.

3. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудыг үл харгалзан олон улсын тээврийн хөлөг онгоц болон агаарын хөлөг дотор гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хувьд авсан шагнал урамшилд тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага нь байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

16 дугаар зүйл. Захирлуудын шагнал урамшил

Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дугаар компанийн Захирлуудын зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагын гишүүний хувьд авсан цалин болон түүнтэй адилтгах бусад төрлийн шагнал урамшилд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

17 дугаар зүйл. Урлагийн ажилтнууд ба тамирчид

1. Энэхүү Конвенцийн 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч театр, кино жүжигчин, радио буюу телевизийн урлагийн ажилтан, хөгжимчин буюу тамирчин Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад хувийн тоглолт хийж олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. 7, 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан, урлагийн ажилтан, тамирчны олсон орлого өөрт нь биш бусад этгээдэд ногдож байгаа тохиолдолд уг орлогод тоглолт болсон тухайн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

3. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан, Хэлэлцэн тохирогч хоёр Улсын тохирсон соёлын буюу биеийн тамирын солилцооны хөтөлбөрийн хүрээнд энэхүү зүйлийн 1 дүгээр заалтад заасан үйл ажиллагаанаас олсон орлого нь дээрх үйл ажиллагааг явуулсан Хэлэлцэн тохирогч Улсад татвараас чөлөөлөгдөнө.

18 дугаар зүйл. Тэтгэвэр

1. 19 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч этгээдийн урьд хийж байсан ажилтай нь холбоотой олгосон тэтгэвэр болон түүнтэй адилтгах бусад төлбөрт

зөвхөн тухайн Улсад татвар ногдуулна.

2. Хэрэв Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч болсон бол уг оршин суугчийн Хэлэлцэн тохирогч Улс дугаар эрхэлж байсан ажлаа зогсоосонтой холбоотойгоор хүлээн авсан нөхөн төлбөр болон бусад нэг удаагийн төлбөрийн орлогод зөвхөн эхний Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Энэ хэсэгт нөхөн төлбөр гэдэг нь шилжихээсээ өмнө ажиллаж байсан албан газар, ажил олгогчоос хийж байсан ажил үүргээ зогсоосонтой нь холбогдуулан олгосон аливаа төлбөрийг хэлнэ.

19 дүгээр зүйл. Засгийн газрын алба

1. а) Хэлэлцэн тохирогч Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс тэр Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хашиж байсны хувьд хувь этгээдэд төлж байгаа тэтгэврээс бусад шагнал урамшил, нөхөн төлбөрт зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

б) Хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад алба хааж байгаа ба тэндхийн байнга оршин суугч бол тийм шагнал урамшилд Хэлэлцэн тохирогч тухайн Улс урамшилд татвар ногдуулна. Уг хувь этгээд нь;

i/ Тухайн улсын харъяат бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө улсын харъяат биш бол, буюу

ii/ гагцхүү алба хаших үүднээс нөгөө Улсын байнга оршин суугч болоогүй бол.

2. а) Хэлэлцэн тохирогч Улсын буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хашиж байсны хувьд хувь этгээдэд тэр Улс буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сангаас олгосон аливаа тэтгэвэрт зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

б) гэхдээ уг хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч бөгөөд тэр Улсын харъяат ба тэтгэвэр тогтоосон Улсын харъяат биш бол тийм тэтгэвэрт зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна.

3. Хэлэлцэн тохирогч Улс буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс аж ахуйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой алба хаасны хувьд олгосон шагнал урамшил болон тэтгэвэрт 15,16 болон 18 дугаар зүйлүүд хамаарна.

20 дугаар зүйл. Багш нар болон профессорууд

1. Хэлэлцэн тохирогч Улсын их сургууль, коллеж, сургууль буюу тэр Улсын Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн боловсролын буюу эрдэм шинжилгээ судалгааны байгууллагад хичээл заах буюу судалгаа хийх зорилгоор хоёр жилээс илүүгүй хугацаагаар ирсэн хувь этгээд нь ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч

байсан бөгөөд байгаа тохиолдолд уг хувь этгээдийн хичээл зааж, судалгаа хийж олсон аливаа орлогыг эхний дурдсан Хэлэлцэн тохирогч Улсад татвараас чөлөөлнө.

2. Энэ зүйлийн заалт нь хувь этгээдийн эрх ашгийн төлөө бус олон нийтийн эрх ашгийн тулд хувь хүн хийсэн судалгаанаас бий болсон орлогод хамаарна.

21 дүгээр зүйл. Оюутнууд

1. Хэлэлцэн тохирогч Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч байсан буюу одоо оршин суугч хэвээр байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч Улсад гагцхүү суралцах, дадлага хийх зорилгоор ирсэн оюутан, сурагчийн өөрийгөө тэжээх, суралцах буюу дадлага хийхэд зарцуулах орлого нь тухайн Улсын гадна орших эх үүсвэрээс гаралтай бол уг орлого нь эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч Улсад татвараас чөлөөлөгдөнө.

2. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гагцхүү суралцах, дадлага хийх зорилгоор ирсэн оюутан, сурагчийн өөрийгөө тэжээх, суралцах буюу дадлага хийхэд зарцуулах орлогыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад анх ирсэн өдрөөс эхлэн таван жилээс илүүгүй хугацаагаар тухайн Улсад татвараас чөлөөлнө.

22 дугаар зүйл. Бусад орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн олж буй энэхүү Конвенцийн өмнөх зүйлүүдэд хөндөгдөөгүй аливаа орлогод зөвхөн Хэлэлцэн тохирогч тухайн Улсад татвар ногдуулна.

2. Хэрэв орлого олгогч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дугаар төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дугаар төвлөсөн газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд уг орлоготой холбогдсон эрх ба эд хөрөнгө нь энэ төлөөлөгчийн газар буюу төвлөсөн газартай шууд холбоотой бол 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлогдсон үл хөдлөх хөрөнгийн орлогоос бусад орлогын хувьд энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нөгөө улсын өөрийнх нь хуулийг баримтлана.

23 дугаар зүйл. Хөрөнгө

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн эзэмшиж байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг 6 дугаар зүйлд дурдсан үл хөдлөх хөрөнгөөр илэрхийлэгдэж байгаа хөрөнгөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн байнгын төлөөлөгчийн газар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрлаж, түүний үйл ажиллагаанд ашиглагддаг хөрөнгийн зарим хэсгийг бүрдүүлэгч хөдлөх

хөрөнгө буюу бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харъяалагдах хөдлөх хөрөнгөд төлөөлөгчийн газар буюу товлосон газар байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

3. Олон улсын шугамд ашиглагдаж буй хөлөг онгоц, нисэх онгоц болон уг хөлөг онгоц, нисэх онгоцны үйл ажиллагаанд хамаарагдах хөдлөх хөрөнгөд тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг зөвхөн тэр Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

4. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн бусад бүх төрлийн хөрөнгөд зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

4 ДҮГЭЭР БҮЛЭГ

ДАВХАР ТАТВАРЫГ АРИЛГАХ АРГУУД

24 дүгээр зүйл. Давхар татвар ногдуулахгүй байх

1. Давхар татварыг энэхүү зүйлийн дор дурдсан заалтуудын дагуу дагуу арилгана.

2. Монгол Улсын хувьд:

Энэхүү Конвенцийн заалтуудтай холбож, Монголын байнгын оршин суугч Итали Улсад татвар ногдуулж болохуйц орлого олж эсвэл хөрөнгө эзэмшиж байвал, Монгол Улс:

а) тухайн байнгын оршин суугчийн орлогод ногдуулсан татвараас Италид төлсөн орлогын татвартай тэнцүү хэмжээний татварыг хөнгөлж өгнө.

б) тухайн байнгын оршин суугчийн хөрөнгөд ногдуулсан татвараас Италид төлсөн хөрөнгийн татвартай тэнцүү хэмжээний татварыг хөнгөлж өгнө.

Гэхдээ аль ч тохиолдолд, тухайн хөнгөлөлт нь Италид ногдуулж болох орлого эсвэл хөрөнгөд хамаарах хөнгөлөлт үзүүлэхээс өмнө тооцогдсон орлого ба хөрөнгийн тэр хэсгээс хэтэрч болохгүй.

3. Итали Улсын хувьд:

Италийн байнга оршин суугч Монголд татвар ногдуулж болох орлого олж байгаа буюу хөрөнгө эзэмшиж байгаа бол Итали энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасны дагуу өөрийн орлогын татварыг тодорхойлохдоо Конвенцийн тусгай заалтуудад өөрөөр заагаагүй бол чөлөөлөх энэхүү орлогын татварыг хамааруулна. Тийм тохиолдолд, Итали орлогын татварыг тооцохдоо Монголд төлсөн татвараас хасаж тооцно, гэхдээ татварын хөнгөлөлт нь дээр дурдсан Италийн татварын орологын нийт дүнгийн харьцаанаас илүү гарахгүй байна.

Италийн хуулийн дагуу тухайн орлого авч байгаа этгээдийн хүсэлтээр тухайн орлогод эцсийн дундын суутгалын татвар ногдуулсан тохиолдолд хасалт хийхгүй.

4. Энэ зүйлийн 2 ба 3 дугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч тухайн Улсад бий болсон ногдол ашиг, хүү, эрхийн шимтгэлийн орлогод Хэлэлцэн тохирогч тухайн Улсын хуулийн дагуу хязгаарлагдмал хугацаагаар чөлөөлөгдөж байвал тухайн чөлөөлөгдсөн буюу хөнгөлөгдсөн татварыг дараах хязгаарт багтаан төлөгдсөн гэж тооцно.

а. 10 дугаар зүйлийн 2 дугаар заалтын "а" хэсэгт заасан ногдол ашгийн нийт орлогын 5 хувь

б. 10 дугаар зүйлийн 2 дугаар заалтын "б" хэсэгт заасан ногдол ашгийн нийт орлогын 15 хувь

в. 11 дүгээр зүйлд заасан хүүгийн нийт орлогын 10 хувь

г. 12 дугаар зүйлд заасан эрхийн шимтгэлийн нийт орлогын 5 хувь

5 ДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗААЛТУУД

25 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхах явдал гаргахгүй байх

1. Хэлэлцэн тохирогч Улсын харъяат Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар төлөх болон түүнтэй холбоотой бусад шаардлагын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын харъяатаас татварын адилгүй буюу илүү хүндрэлтэй нөхцөлд оруулахгүй.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг төлөөлөгчийн газрын татвар төлөх нөхцөлийг нөгөө Улсын түүнтэй адилтгах төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн татвар төлөх нөхцлөөс доогуур байлгаж болохгүй. Энэ заалт нь Хэлэлцэн тохирогч Улс нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчдыг иргэний эрх, гэр бүлийн хариуцлагын хувьд өөрийн байнга оршин суугчийн хувьд татвараас чөлөөлөх, хөнгөлөх, барасгах эрх эдлүүлэх ёстой гэсэн утгаар хэрэглэгдэхгүй.

3. 9 дүгээр зүйл, 11 дүгээр зүйлийн 7 дугаар заалт, 12 дугаар зүйлийн 6 дугаар заалтыг хэрэглэхээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар ногдох ашгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлж буй хүү, эрхийн шимтгэл болон бусад төлбөрийг эхний Улсын байнга оршин суугч этгээдэд төлсөнтэй адил нөхцөлөөр хасч хөнгөлнө. Үүний нэгэн адилаар, Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар ногдох хөрөнгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчид төлсөн аливаа өрийг эхэнд дурдсан Улсын байнга оршин суугчийн хувьд тохиролцсонтой адил нөхцлөөр хасч тооцно.

4. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн хөрөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч нэг буюу хэсэг этгээд шууд

буюу шууд бусаар бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн өмчилж буюу хянаж байвал Хэлэлцэн тохирогч Улс өөрийн адил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татвар төлөх буюу түүнтэй холбоотой шаардлагаас өөр буюу илүү хүндрэлтэй байдалд оруулах хариуцлага ногдуулахгүй.

5. 2 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан энэ зүйлийн заалтууд нь бүх төрлийн татварт хэрэглэгдэнэ.

6. Гэвч дээр дурдсан энэ зүйлийн өмнөх заалт нь татварын хууль дугаар татвараас зайлсхийх зорилготой үйл ажиллагаа, харилцааг зохицуулах зорилготой заалтуудад үл нөлөөлнө.

26 дугаар зүйл. Харилцан тохирох журам

1. Хэрэв аливаа этгээд Хэлэлцэн тохирогч аль нэг Улс буюу хоёр Улс хоёулаа энэхүү Конвенцид заагдаагүй татвар түүнд ногдуулсан буюу ногдуулах боллоо гэж үзвэл тухайн Улсуудын дотоодын хууль тогтоомжийн заалтуудыг үл харгалзан өөрийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч Улсынхаа эрх бүхий байгууллагад буюу хэрэв тухайн тохиолдол нь 25 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад хамаарч байвал өөрийн харъяат Хэлэлцэн тохирогч Улсад гомдлоо гаргаж болно. Гомдлыг энэхүү Конвенцид заагдаагүй татвар ногдуулж байна гэж анх мэдсэнээс хойш 2 жилийн дотор гаргана.

2. Гомдлыг нотолж хангалттай шийдвэр гаргах боломжгүй бол Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллага энэхүү Конвенцид заагдаагүй татвар ногдуулахгүй байх зорилгоор харилцан тохирох бүх арга хэмжээ авна. Аливаа тохиролцоог Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомжийн цаг хугацааны хязгаарлалтыг үл харгалзан хэрэгжүүлнэ.

3. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь энэхүү Конвенцийг хэрэглэх болон тайлбарлахад үүсэх аливаа хүндрэлтэй болон эргэлзээтэй асуудлуудыг харилцан тохирох замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Мөн түүнчлэн энэхүү Конвенцид заагдаагүй орлогыг давхар татвараас чөлөөлөх асуудлыг тэд харилцан зөвлөцөж болно.

4. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь өмнөх заалтуудын талаар тохиролцоонд хүрэх зорилгоор өөр хоорондоо шууд харилцаж болно. Хэрэв шаардлагатай бол тохиролцоонд хүрэхийн тулд Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчид амаар санал солилцох зорилгоор энэхүү уулзалт нь Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн Комиссоор дамжин хэлэлцэгдэнэ.

27 дугаар зүйл. Харилцан мэдээлэл солилцох

1. Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллагууд энэхүү Конвенцид хамрагдах заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс, энэхүү

Конвенциор зохицуулагдах татварын талаарх хоёр Улсын хууль тогтоомж болон уг шаардагдах мэдээллийг харилцан солилцож байна. Хоёр улсын татварын талаарх хууль тогтоомж, татвар ногдуулалт нь энэхүү Конвенц түүний дотор татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд харшлах ёсгүй. Харилцан мэдээлэл солилцох явдлыг 1 болон 2 дугаар зүйлүүдээр хязгаарлахгүй. Хэлэлцэн тохирогч Улс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсаас хүлээн авсан мэдээллийг Хэлэлцэн тохирогч Улс өөрийн улсын мэдээлэл хадгалах хуулийн дагуу нууцалж зөвхөн энэхүү Конвенцид хамаарагдах татварын хэмжээг тогтоох буюу хураахтай холбогдсон этгээдүүд, эрх барих байгууллагуудад (шүүх, захиргааны байгууллагыг оролцуулан) мэдэгдэх эрхтэй. Тэдгээр этгээд буюу эрх барих байгууллагууд нь уг мэдээллийг зөвхөн энэхүү зорилгод ашиглана. Түүнчлэн тэд дээрх мэдээллийг олон нийтийн шүүхийн протокол, шүүхийн шийдвэрт тусгаж болно.

2. 1 дүгээр зүйлийн заалтууд нь ямар ч тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсад дараах үүргийг хүлээлгэх ёсгүй.

а) Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээнд харшлах захиргааны арга хэмжээ авах,

б) Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж болон захиргааны ердийн үйл ажиллагааны дагуу олж үл болох мэдээлэл буюу баримт бичгээр хангах,

в) Хэлэлцэн тохирогч Улсуудын аливаа худалдаа, бизнес, аж үйлдвэр, арилжааны буюу мэргэжлийн нууц алдагдуулах мэдээ болон нийгмийн хэв журамд харшлах мэдээллээр хангах.

28 дугаар зүйл. Дипломат ба консулын ажилтнууд

Энэхүү Конвенц нь олон улсын эрх зүйн түгээмэл хэм хэмжээ болон тусгай Конвенцийн заалтуудын дагуу дипломат ба консулын ажилтнуудын санхүүгийн эрх дархыг үл хөндөнө.

29 дүгээр зүйл. Хөнгөлөлтийн хязгаарлалт

1. Энэхүү Конвенцид өөрөөр заагаагүй бол байнга оршин суугч үндсэн зорилго буюу үндсэн зорилгын нэг нь энэ Конвенцийн ашиг тусыг хүртэх зорилготой бол Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын татвараас энэхүү Конвенцийн дагуу чөлөөлөгдөхгүй, хөнгөлөлт эдлэхгүй.

2. Энэхүү Конвенц нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байгуулагдсан аж ахуйн нэгж болон Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн хооронд шилжүүлгээс бий болсон аливаа хасалт, зардлын хязгаарлалттай холбоотой татвараас зайлсхийх явдлаас сэргийлэх зорилго бүхий тухайн улсын дотоодын журам, зохицуулалтыг хөндөхгүй.

6 ДУГААР БҮЛЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

30 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү Конвенцийг соёрхон батлах ёстой бөгөөд соёрхон баталсан баримт бичгийг аль болох хурдан хугацаанд*Рем*....-д харилцан солилцоно.

2. Соёрхон баталсан баримт бичгийг харилцан солилцсон өдрөөс энэхүү Конвенц хүчин төгөлдөр болох бөгөөд түүний заалтууд дор дурдсаны дагуу үйлчилж эхлэнэ;

а) Конвенц хүчин төгөлдөр болсон жилийн дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн эх үүсвэрт нь суутгалаар төлсөн буюу хөнгөлсөн зохих татварууд,

б) Конвенц хүчин төгөлдөр болсон жилийн дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа татварын жилд төлбөл зохих бусад татваруудад.

31 дүгээр зүйл. Дуусгавар болох хугацаа

Энэхүү Конвенцийг Хэлэлцэн тохирогч аль нэг Улс цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөнө. Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараах хуанлийн жил дуусахаас наанадаж 6 сарын өмнө уг Конвенцийг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч аль ч Улс дипломат шугамаар, бичгээр мэдэгдэж болно. Энэ тохиолдолд уг Конвенц дараах хүрээнд үйлчлэхээ болино.

а) бичгээр мэдэгдэл өгсөн жилийн дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн эх үүсвэрт нь суутгалаар төлсөн буюу хөнгөлсөн зохих татварууд,

б) бичгээр мэдэгдэл өгсөн жилийн дараагийн хуанлийн 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа татварын жилд төлбөл зохих бусад татварууд.

Дээр дурдсаныг нотолж, зохих ёсоор эрх олгогдсон дараах хүмүүс энэхүү Конвенцид гарын үсэг зурав.


Гаднаад Харилцааны Төв архив

Энэхүү Конвенцийг *Длааньдатор* хотноо 200.3 оны 9... дугаар сарын 11-ний өдөр монгол, итали болон англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлах буюу хэрэглэхэд маргаан гарах тохиолдолд англи хэлээр эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



Цахим ашиглалтын хувь

Гадаад харилцааны төв архив

НЭМЭЛТ ПРОТОКОЛ

"Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар хоорондын Конвенц"-д оруулах нэмэлт протокол.

"Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар хоорондын Конвенц"-д гарын үсэг зурснаар уг Конвенцийн салшгүй хэсэг болсон дараах нэмэлт заалтууд нь хүчин төгөлдөр болно. Үүнд:

1. 2 дугаар зүйлийн 3 дугаар заалтын а-д зааснаар ирээдүйд Итали улс хөрөнгөнд татвар тогтоовол энэхүү Конвенцид түүнийг тусгах /хэрэглэх/ бөгөөд давхар татварыг уг Конвенцийн 24 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэн хүчингүй болгоно.

2. 7 дугаар зүйлийн 3 дугаар заалтад заасан "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд зориулан зарцуулсан зардал" гэдэг нэр томъёонд төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай шууд холбоотой зардлыг хамааруулж ойлгоно.

3. 8 дугаар зүйлд заасан усан болон нисэх онгоцоор олон улсын тээвэр хийж олсон ашигт:

а/ олон улсын тээвэрт ашиглагдаж буй хоосон усан онгоц, нисэх онгоцны түрээсийн татвараас олсон ашиг,

б/ чингэлэг хэрэглэсэн, түрээсийн татвараас олсон ашиг - /Ийм төрлийн ашиг нь усан болон нисэх онгоцоор олон улсын тээвэр хийж олсон бусад ашгийн үр дагавар болж байвал/-ууд хамаарагдана.

4. 10 дугаар зүйлийн 4, 11 дүгээр зүйлийн 5, 12 дугаар зүйлийн 4, 22 дугаар зүйлийн 2 дугаар заалтууд болон сүүлчийн өгүүлбэр нь энэхүү Конвенцийн 7, 14 дугаар зүйлүүдийн биелэлээ олсон зарчмуудыг зөрчихгүй.

5. 26 дугаар зүйлийн 3 дугаар заалтад заасны дагуу эрх бүхий байгууллагууд Конвенцийг тайлбарлахад гарсан аливаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол эрх бүхий байгууллага болон татвар төлөгчдийн зөвшөөрсний үндсэн дээр хийгээд татвар төлөгч нь арбитрын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үүргийг хүлээхээ илэрхийлэх нөхцөлтэйгээр хэргийг Арбитрын шүүхэд шилжүүлж болно. Хоёр улс тухайн хэргийн талаарх Арбитрын шүүхийн гаргасан шийдвэрийг гүйцэтгэх үүрэгтэй. 26 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад заасны дагуу хоёр улс холбогдох журмыг баталж, эрх бүхий байгууллагууд ноот

Гадгаад харилцааны төв архив

бичгээр харилцан солилцох ёстой. Энэ заалт нь эрх бүхий байгууллагууд ноот бичиг харилцан солилцсоны үндсэн дээр хүчин төгөлдөр болно.

6. Хэрэв татвар ногдуулах эрх нь энэ Конвенцийн заалтуудаар зохицуулагдаж байгаа тохиолдолд Хэлэлцэн тохирогч нэг улс дугаар эх үүсвэрт суутган авсан татваруудыг татвар төлөгчийн хүсэлтээр буцаан олгоно. Буцаан олголт хийх талаар тухайн хэлэлцэн тохирогч улсын хуульд заасан хязгаарт багтааж буцаан авах тухай өргөдөл нь тухайн татвар төлөгчийн байнгын оршин суугч болохыг нотолсон бөгөөд энэхүү Конвенциор олгогдсон давуу талуудыг хэрэглэх эрхтэйд тооцогдох нөхцөлүүд байгаа эсэхийг илтгэсэн эрхийн бичгийг хавсаргасан байна. Энэхүү заалт нь энэ Конвенциор олгогдсон давуу талуудыг өөр бусад арга хэлбэрээр хэрэглэх аргын эрхийг хязгаарлахгүй.

7. Энэхүү Конвенцийн аль ч заалт нь татвараас зугатах, татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх үүднээс хэлэлцэн тохирогч улсуудын аль аль нь өөрсдийн дотоодын хууль, тогтоомжийг хэрэглэх явдлыг хязгаарлахгүй.

Дээр дурдсаныг нотолж, зохих ёсоор эрх олгогдсон дараах хүмүүс энэхүү Конвенцид гарын үсэг зурав.


Энэхүү Конвенцийн нэмэлт Протоколыг *Улаанбаатар* хотноо 200...3 оны ...9... дугаар сарын *11-н* өдөр монгол, итали болон англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Тайлбарлах буюу хэрэглэхэд маргаан гарах тохиолдолд англи хэлээр эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



Гаднаад харилцааны төв архив

CONVENTION

BETWEEN THE GOVERNMENT OF THE ITALIAN REPUBLIC AND THE GOVERNMENT OF MONGOLIA FOR THE AVOIDANCE OF DOUBLE TAXATION WITH RESPECT TO TAXES ON INCOME AND ON CAPITAL AND THE PREVENTION OF FISCAL EVASION.

4.5

21

CONVENTION


BETWEEN THE GOVERNMENT OF THE ITALIAN REPUBLIC AND THE GOVERNMENT
OF MONGOLIA FOR THE AVOIDANCE OF DOUBLE TAXATION WITH RESPECT TO
TAXES ON INCOME AND ON CAPITAL AND THE PREVENTION OF FISCAL EVASION.

initialled in Ulaanbataar

on 21st June 2001

by

For the Italian
Delegation



(M.- del Giudice)

For the Mongolian
Delegation



(N. Tumendemberel)

The Government of the Italian Republic and the Government of Mongolia,

Desiring to conclude a Convention to avoid double taxation with respect to taxes on income and on capital and to prevent fiscal evasion

Have agreed upon the following measures:

H. J.

dy

Chapter I

Scope of the Convention

Article 1

PERSONAL SCOPE

This Convention shall apply to persons who are residents of one or both of the Contracting States.

H.T

2/2

Article 2

TAXES COVERED

1. This Convention shall apply to taxes on income and on capital imposed on behalf of each Contracting State or of its political or administrative subdivisions or local authorities, irrespective of the manner in which they are levied.

2. There shall be regarded as taxes on income and on capital all taxes imposed on total income, on total capital or on elements of income or capital, including taxes on gains from the alienation of movable or immovable property, taxes on the total amounts of wages or salaries paid by enterprises, as well as taxes on capital appreciation.

3. The existing taxes to which the Convention shall apply are in particular:

4.5 (a) in the case of Italy:

- 1 - the personal income tax (l'imposta sul reddito delle persone fisiche);
- 2 - the corporate income tax (l'imposta sul reddito delle persone giuridiche);

whether or not they are collected by withholding at source

(hereinafter referred to as "Italian Tax");

(b) in the case of Mongolia:

- 1 - the individual income tax;
- 2 - the corporate income tax;
- 3 - the immovable property tax;

(hereinafter referred to as "Mongolian tax");

